



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 14

№ 03/09

Улаанбаатар хот

АЙМГИЙН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ ТАНАА

Комисст “Хөөрхөн зүрхнүүдийн аян” Төрийн бус байгууллагаас аймгийн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагч охидыг хүчээр шээлгэж, жирэмсний тестээр шалгасан байна. Дээрх үйлдэл нь сурагчдын бэлгийн болон нөхөн үржихүйн халдашгүй байдлыг ноцтойгоор зөрчиж байна” гэх мэдээллийг ирүүлжээ.

Комисс мэдээллийн мөрөөр холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга авах зэрэг ажиллагаа явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

Хөвсгөл аймгийн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал “Багш нарын зөвлөгөөнөөр охидын үзлэг хийх талаар шийдвэр гарсан ч үзлэгийг одоогийн байдлаар хийгээгүй. Гэхдээ эрсдэлтэй сурагчдаасаа эцэг, эхийн зөвшөөрөлтэйгөөр үзлэг хийнэ”, мөн сургуулийн эмч “Сумын эрүүл мэндийн төвийн эх баригчтайгаа хамтраад эхлээд 8-9 дүгээр ангийн сурагчдаас, үүний дараа 10-11 дүгээр ангийн сурагчдаасаа сургуулийн бие засах өрөөндөө шинжилгээ авсан”, мөн үзлэгт хамрагдсан сурагчдаас “Үзлэгт хамрагдсан нь үнэн бөгөөд сургуулийн бие засах өрөөнд тестээр шинжилгээ авсан” гэж тус тус Комисст тайлбар өгснөөс үзэхэд тус сургуулийн эрх бүхий албан тушаалтнууд нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй сургуулийн орчинд сурагч охидоос хүсээгүй байхад нь жирэмсний тестээр шинжилгээ авсан нь олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан халдашгүй дархан байх, охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх, хэнийг ч дур мэдэн эмнэлгийн туршилтад өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр оруулахгүй байх эрхийг зөрчсөн үйлдэл байна.

Комисс сургуулийн орчинд анги, бүлэг, нийтээр нь хийдэг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд “охидын үзлэг”-ийг нэгдсэн байдлаар зохион байгуулахыг таслан зогсоох, суралцагчдын эрүүл мэндийн нууцыг чанд хадгалж, өсвөр үеийнхнийг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн зөвлөгөө, шинжилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдад 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 1/35 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн.

Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын газрын дарга Нийслэлийн боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт сургуулийн орчинд охидын үзлэг зохион байгуулахгүй байх тухай 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 6/2192 тоот албан бичиг хүргүүлсэн байна.

Мөн охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох хүрээнд НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2018 оны хамтарсан мэдэгдэлд "... "онгон хальсны үзлэг" нь эрүүл мэндийн болон шинжлэх ухааны үүднээс онцын шаардлагагүй төдийгүй ихэвчлэн өвдөлт ихтэй, дарамттай, ичгэвтэр мэдрэмж төрүүлсэн үзлэг байдаг бөгөөд үүнийг таслан зогсоох шаардлагатай" гэж онцлон, хүний эрхийн ноцтой зөрчил гэж үзсэнийг энд дурдах нь зүйтэй байна.

Иймд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Комиссын гишүүний Шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:

1. Эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд буюу сургуулийн орчинд охидын үзлэгийг дахин зохион байгуулахгүй байх;
2. Аливаа шийдвэр гаргахдаа хүний эрхийн зарчмыг удирдлага болгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвшөөрөөгүй, хүсээгүй байхад охидыг хүчээр үзлэгт хамруулахгүй байх;
3. Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар багш, ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, Боловсрол, шинжлэх ухааны сайдад хүргүүлсэн Комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 1/35 дугаартай зөвлөмжийг багш, ажилтнуудад танилцуулах;
4. Нийт сурагчдад бэлгийн боловсрол олгох үйл ажиллагааг идэвхитэй дэмжиж, эрүүл мэндийн хичээлийн чанар, хүртээмжийг сайжруулах;

Шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор бичгээр хариу ирүүлнэ үү.

Жич: Боловсрол, шинжлэх ухааны сайдад хүргүүлсэн 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 1/35 дугаартай зөвлөмжийг хавсаргав.

ГИШҮҮН  Х.МӨНХЗУЛ



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС  
ЗӨВЛӨМЖ

2021 оны 08 дугаар сарын 31

Дугаар 1/25

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД  
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Дэлхийн улс орнууд Ковид-19 цар тахалын үед олон сорилт, хүндрэл бэрхшээлтэй тулгарч, түүний дотор хүүхэд, суралцагчдын сурч боловсрох эрх хязгаарлагдаж байгаа нь анхаарах шаардлагатай асуудлын нэгт зүй ёсоор тооцогдож байна. Монгол Улс Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн боловсролын бүх шатны танхимын сургалтыг зогсоож, цахим хэлбэрт шилжүүлснээр хүүхдүүд танхимаар хичээллэх үеийнхтэй адил мэдлэг, мэдээлэл авах бололцоогүй болохын зэрэгцээ интернэтгүй, компьютергүй, сүлжээгүй, алслагдсан сум, гэр хороололд оршин суудаг зарим хүүхдүүд цахим болон зайны сургалтад оролцох нөхцөл, боломжгүйн улмаас сурлагын хоцрогдол, сургууль завсардалтын бодит эрсдэл үүссэн.

Боловсролын хүрээлэнгийн хийсэн судалгаагаар 2019-2020 онд хичээлийн агуулгын алдагдал 47-53 цаг байсан бол 2020-2021 онд 110 цаг буюу 28 хувьд хүрчээ. Үүнээс гадна танхимын сургалтыг урт хугацаанд зогсоосноор асран хамгаалах хүнгүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүд орон гэртээ ганцаар үлдэж ахуйн осол, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, улмаар амь нас, эрүүл мэндээр хохирох, хөдөлгөөний дутагдалд орох, таргалалт болон бусад өвчинд өртөмтгий болох, гар утас, компьютер, зурагт дэлгэцийн хамааралтай болох, хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртөх зэргээр эрүүл мэнд, сэтгэл зүйгээр хохирсон тохиолдол цөөнгүй байна.

Монгол Улсын Засгийн газар цар тахлын улмаас хоёр жил тасалдсан танхимын хичээлийг 2021-2022 оны хичээлийн жил эхлүүлэхтэй холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/290 дугаар "Их дээд, сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар "Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед цэцэрлэгийн сургалт үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам", "Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам", мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/190 дугаар "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө (2021-2023)"-г тус тус баталж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь сайшаалтай байна.

Монгол Улс цар тахлын үед ч нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар хүлээсэн боловсролыг бүх нийтэд эрх тэгш.


152100021

хүртээмжтэй, чанартай олгох үүргээ биелүүлж, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжих болон сурч боловсрох эрхийг хангах, хамгаалах шаардлага тулгарч байна.

Иймд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т заасныг тус тус үндэслэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Зөвлөмжийг хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛООН,  
ГҮЙЦЭТГЭГЧ, ГИШҮҮН



Ж.ХУНАН

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЗӨВЛӨМЖ

### **Ковид-19 цар тахлын үеийн боловсролын асуудлын хүрээнд:**

1. Ковид-19 цар тахлын үед боловсролын салбарт хэрэгжүүлэх хариу арга хэмжээний стратеги, бодлого, төлөвлөгөөний талаар боловсролын салбарын оролцогчид болон олон нийтэд нэгдмэл, ойлгомжтой мэдээлэл өгөх;
2. Сургуулийн орчинд суралцагчид бие биенээ коронавируст халдвараар өвдсөн эсвэл вакцинд хамрагдсан, хамрагдаагүй гэх шалтгаанаар дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, хэл амаар доромжлох, нэр хоч өгөх зэргээр бие махбодын, сэтгэл санааны дарамт учруулах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, таслан зогсоох, хяналт тавих дүрэм, журам боловсруулж, бүх шатны боловсролын байгууллагуудад чанд мөрдүүлэх;
3. Бүх шатны сургалтын байгууллагын удирдлага, багш, ажиллагчид коронавируст халдвараар өвдсөн хэн нэгнийг эрхэлж буй ажил, хөдөлмөрийн харилцаатай холбоотой ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэл үзүүлэхийг хориглох, тэдний хэвийн ажиллах нөхцөл боломжоор хангах, төрийн албан хаагчдийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх, энэ төрлийн зөрчлийг дахин гаргуулахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авах, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллийн тохиолдол илэрсэн үед зохих шат шатны байгууллага, удирдлагуудад хариуцлага тооцох;
4. Ковид-19 цар тахлын улмаас аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа доголдож айл, өрхүүдийн орлого буурсан, үүнтэй холбоотойгоор төлбөртэй сургуульд суралцагчдад сургалтын төлбөрийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх, өмчийн хэлбэр үл харгалзан сургалт, дотуур байрны төлбөрийг нэмэхгүй байх, санхүүгийн боломжгүйн улмаас суралцагчдын сурч боловсрох эрх зөрчигдөхгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах, зохицуулалтыг хийх;
5. Боловсролд хүн бүрийг тэгш хамруулах, ялангуяа тусгай хэрэгцээт суралцагчдад тэдний онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хөтөлбөр, арга, хэлбэрийг боловсруулан, хэрэгжүүлэх. Ингэхдээ эдгээр хүүхдүүд хичээлээ давтах, гэрийн даалгавраа хийхэд нь хамт байж туслах, сэтгэл санааг нь ойлгодог байх чиглэлээр эцэг, эхчүүдэд зориулсан зөвлөгөө, мэдээлэл хүргэх, арга зүй бий болгох, гэрээр хичээллэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэх;
6. Коронавируст халдвар, эрсдэл ихэсч сургуулийн үйл ажиллагааг зогсоох тохиолдолд Ковид-19 цар тахлын голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжоор хангах уян хатан бодлого, арга хэмжээг авч, хэрэгжүүлэх.

### **Сурч боловсрох эрхийн хүрээнд:**

1. Сургалтын төрийн сангийн буцалтгүй тусламжаар суралцаж буй оюутнуудын сургалтын төсөв батлагдаагүй үндэслэлээр их, дээд сургуулийн төлбөрийн тодорхой хувийг төлөхийг шаардах, төлбөр төлөөгүй нөхцөлд хичээл сонголт хийх боломжгүй болох зэрэг сурч, боловсрох эрх зөрчигдөж болзошгүй тул сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, зээл, тэтгэлгийг тасралтгүй олгох;

2. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, мэдээг бүх шалгуулагчдын овог, нэрээр нь жагсаан гаргаж, хэн ч танилцах боломжтой байгаа нь хувь хүний нууц алдагдах, нэр төрд нь халдах, ялгаварлан гадуурхалтад өртөх зэрэг хүний эрх зөрчигдөж болзошгүй тул шалгуулагчдыг овог, нэрээр нь бус дугаар буюу код олгож ажиллах, хувийн нууцлалыг хамгаалах;
3. Сургуулийн орчинд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх;
4. Зарим ерөнхий боловсролын сургуулийн зүгээс суралцагчдыг харьяаллын дагуу бүртгэхдээ үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ зэргийг шаардаж байгаагаас эцэг, эх болон сургуулийн захирал, удирдлагын хооронд үл ойлголцол үүсч, хүүхэд сургуульд элсэн орох болон шилжин суралцахад хүндрэл учирч байгаа талаар мэдээлэл ирсэн байгаа тул холбогдох арга хэмжээг авах;
5. Вакцинд хамрагдсан эсэхээс үл хамаарч сурч боловсрох эрхээ бүх хэлбэр, түвшний боловсролын байгууллагад баталгаатай эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх.

**Охид, эмэгтэйчүүдийн эрхийн хүрээнд:**

1. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох хүрээнд НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2018 оны хамтарсан мэдэгдэлд " ... "онгон хальсны үзлэг" нь эрүүл мэндийн болон шинжлэх ухааны үүднээс онцын шаардлагагүй төдийгүй ихэвчлэн өвдөлт ихтэй, дарамттай, ичгэвтэр мэдрэмж төрүүлсэн үзлэг байдаг бөгөөд үүнийг таслан зогсоох шаардлагатай" гэж онцлон, хүний эрхийн ноцтой зөрчил гэж үздэг. Монгол Улсад зарим аймаг, орон нутагт ерөнхий боловсролын сургууль "Охидын үзлэг"-ийг нэгдсэн байдлаар зохион байгуулж байгаагаас үүдэн өсвөр насныхны эрүүл мэндийн нууцаа хамгаалуулах эрх зөрчигдөж, хүүхдийн хувийн нууц мэдээлэл задарсан нөхцөлд сургуульд суралцах боломжгүй болж сургууль завсардах, шилжих, сургууль, гэр бүлийнхээ орчинд гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна. Онгон хальсны үзлэг нь НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенцоор хамгаалсан охид, эмэгтэйчүүд халдашгүй дархан байх эрх, хүйсийн байдлаас үүдэн ялгаварлан гадуурхалтад өртөхөөс хамгаалагдах эрх, амьд явах эрх, хүүхдийн эрх, хувийн нууцлал, орон зай болон бие махбодын хувьд эрх чөлөөтэй байх эрх, тарчлаан зовоох болон тамлалтаас чөлөөтэй байх эрх, эрүүл мэндийн хамгийн дээд зэргийн чанартай үйлчилгээ авах эрх, цаашилбал эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах, хэрцгийлэл, доромжлолоос ангид байх, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулахгүй байх зэрэг эрхүүдийг ноцтойгоор зөрчиж буй хэлбэр юм. Тиймээс сургуулийн орчинд анги, бүлэг, нийтээр нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд "Охидын үзлэг"-ийг нэгдсэн байдлаар хийхийг таслан зогсоох, суралцагчдын эрүүл мэндийн нууцлалыг чанд хадгалж, мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаж, хариуцлагагүй хандсан албан тушаалтнуудад хариуцлага тооцохыг журамлах, өсвөр үеийнхнийг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн зөвлөгөө, шинжилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх.

*Шийн  
Зөвшөөсөн*